

## АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл, IDA credit-P174116
Байршил	Монгол Улс, Улаанбаатар
Ажлын даалгаврын нэр	“Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийн процессын болон үр дүнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ
Үйлчилгээний нэр	“Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийн үнэлгээ хийх үндэсний зөвлөх байгууллага
Гэрээний төрөл	Зөвлөх үйлчилгээ
Хэл:	Монгол болон Англи
Гэрээний хугацаа:	8 сар

### ҮНДЭСЛЭЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”(ОБҮДХЭТ)-ийг Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон техникийн дэмжлэгтэйгээр 2020-2024 онд хэрэгжүүлж байна. Төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан ажил олгогч болон ажилтнуудад богино хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

Төсөл нь үндсэн 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

1) Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тогтолцоог цогц байдлаар шинэчлэн ажил хайгч болон ажил олгогч нарт “үйлчлүүлэгч-төвтэй” үйлчилгээг хувийн зуучлалын байгууллагуудтай хамтран хүртээмжтэй хүргэх;

2) Төслийн хүрээнд сонгосон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэд нийцсэн байдлыг бэхжүүлэх;

3) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

4) Бизнес эрхлэгчид болон ажилтнуудад цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зохих шалгуур хангасан ажиллагчид болон ажил олгогчдод богино хугацааны тэтгэмж олгох бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 2-ын сонгосон хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэд нийцсэн байдлыг бэхжүүлэх хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн онцлог шинэлэг үр чадварыг хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлнэ. Тодруулбал, “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр” (энд Ур чадварын инновацийн хөтөлбөр буюу УЧИХ-ийг ойлгоно)-ийн онцлог нь эрэлтэд суурилсан зөвлөлдөх үүлзалт, салбарын холбоо/зөвлөлүүдийн оролцоо, бие даасан үнэлгээ, нийгэм-бүтээлч зан үйлийн үр чадвар олгох сургалтын нэмэлт модулиуд, мэргэшүүлэх сургалт, өмнөх мэдлэг, үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ болон бусад шинэлэг зүйлсийг багтаасан.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийг 2023 оны 2 дугаар сард баталсан. ХНХЯ-ны харъяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (ХНХСҮСИ) нь хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлыг хариуцаж ажиллана. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамжийг ХНХ-ын сайдын 2023 оны А/145 тоот тушаалаар баталсан бөгөөд удахгүй хэрэгжилтийг эхлүүлэхээр хүлээгдэж байна.

Хөтөлбөрийн хүрээнд 700-аас доошгүй ажил хайгчдад эрэлтэд нийцсэн мэргэжлийн болон харилцаа, зан үйлийн үр чадвар олгох, 300 хүртэлх ажиллагчдыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. ХНХЯ нь төсөл дууссаны дараа ч түс хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийн нэг болгон өргөжүүлэхээр төлөвлөсөн. Сургалт нь төлөвлөгөө ёсоор 2024 оын 03 дугаар сараас 2024 оны 11 дүгээр сарын хооронд зохион байгуулагдана.

Иймд хөтөлбөрийн үнэлгээг хийхдээ хөтөлбөрийн процессын болон үр дүнгийн үнэлгээний хөтөлбөр, боловсруулан хэрэгжүүлэх аргачлалыг сургалтын модультай үялдуулан хийх шаардлагатай. Хөтөлбөрийн нөлөөллийн үнэлгээний судалгааг ХНХЯ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) хариуцаж ажиллана. Харин судалгааг гүйцэтгэх байгууллага нь Дэлхийн банкны болон үндэсний зөвлөхтэй хамтран судалгааны аргачлалыг боловсруулан, аргачлалын дагуу мэдээлэл цуглуулалт, дүн шинжилгээ хийж, үнэлгээний тайланг боловсруулах, зөвлөмж өгөх ажлыг хариуцаж ажиллана.

## ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

**Ажлын хүрээ:** Хөтөлбөрийн агуулга, сургалтын хэлбэр нь зорилгодоо хэр нийцэж, төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн эсэх болон сургалтын үр шим хүртэгчдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцооны өөрчлөлтийг хэмжих нь үнэлгээний гол зорилго юм.

Зорилгыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- Сургалтын хөтөлбөрт оролцогчдын сонголтын оновчтой байдал;
- Нийгэм-бүтээлч зан үйлийн үр чадвар олгох сургалт ба бусад сургалтын хөтөлбөрийн агуулга, суралцагчдад хүргэх хэлбэрийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нь ангилж, ойлгомжтой байдал, үр дүнг нь үнэлэх;
- Сургалтын үр шим хүртэгчдийн хөдөлмөр эрхлэлтэд гарах өөрчлөлтийг үнэлэх.

Дээр дурдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд зөвлөх байгууллага судалгаа зохион байгуулж, хөтөлбөрийн үнэлгээний үе шат бүр дэх тайланг боловсруулан дүгнэж, хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэхэд анхаарах санал, зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэнэ.

**Гүйцэтгэх ажлууд:** Зөвлөх байгууллага нь дараах ажлуудыг гүйцэтгэнэ:

- 1) Дэлхийн банкны зөвлөх болон үндэсний зөвлөхтэй хамтран хөтөлбөрийн үнэлгээний аргачлал, судалгааны асуулгыг боловсруулах;
- 2) Судалгааны тоологч болон ахлагч нарт зориулсан сургалт зохион байгуулах;
- 3) Мэдээлэл цуглуулалтыг төлөвлөх, зохион байгуулах, аргачлалын дагуу мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- 4) Цуглуулсан мэдээллийн чанарт хяналт тавих, баталгаажуулах;
- 5) Хөтөлбөрийн үнэлгээний тайлан боловсруулах, дүгнэлт зөвлөмж бичих.

Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо болон сургалтын байгууллагын хүчин чадлаас хамааран сургалтыг олон байршилд зохион байгуулах бөгөөд тухай бүрт судалгааг зохион байгуулна. Сургалт зохион байгуулах байршил нь Улаанбаатар хот.

### Аргачлалын урьдчилсан санал

Үнэлгээний аргачлал нь судалгааны тавьсан зорилготой шууд хамааралтай. Үнэлгээний аргачлалын үзэл баримтлалыг энэ ажлын даалгаврын Хавсралт 1-д оруулсан. Үзэл баримтлалын дагуу дараах хоёр төрлийн үнэлгээг хийнэ.

## 1. Процессын үнэлгээ

Энэ үнэлгээг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн эсэх, тулгарсан хүндрэл бэрхшээлийг тандах зорилгоор хийнэ. Үнэлгээний дүнд дараах үзүүлэлтүүдийг тодорхойлох шаардлагатай:

- Сургалт төлөвлөгөө, журмын дагуу хэрэгжсэн эсэх;
- Сургалтын хөтөлбөрийн агуулга, хэлбэр нь суралцагчдад тохиромжтой, тохируулсан байсан эсэх;
- Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл тулгарсан эсэх, түүний шийдэл.

## 2. Үр дүнгийн үнэлгээ

Хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн зан үйлийн хандлага болон хөдөлмөрийн зах зээлийн үр дүнгийн өөрчлөлтийг илрүүлэх зорилгоор энэ үнэлгээг хийнэ. Үнэлгээний дүнд дараах үзүүлэлтүүдийг тодорхойлно:

- Ажил хайгчдын зөөлөн үр чадвар өөрчлөгдсөн эсэх (сургалтын дүнд);
- Ажиллагчдын мэргэжлийн үр чадвар өөрчлөгдсөн эсэх;
- Хөтөлбөрт оролцогчдын хөдөлмөрийн зах зээлийн үр дүнд өөрчлөлт орсон эсэх.

### Нийлүүлэх бүтээгдэхүүн:

Зөвлөх байгууллага нь дараах бүтээгдэхүүнийг нийлүүлнэ:

Бүтээгдэхүүн	Хугацаа гэрээ эхэлснээс хойш (ажлын өдрүүд, дор заасан)	Нийлүүлэх хугацаа (дор заасан)	Шаардлагатай хяналт ба баталгаажуулалт
<b>Бүтээгдэхүүн 1. Эхлэлийн тайлан</b> i) Нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөө, хуваарь; ii) Хөтөлбөрийн процессын болон үр дүнгийн үнэлгээний аргачлалын төсөл;	14 хоног	2024.04.18	ТХН, ХНХЯ
<b>Бүтээгдэхүүн 2. Үнэлгээний бэлтгэл ажлын тайлан</b> i) Хөтөлбөрийн процессын болон үр дүнгийн үнэлгээний аргачлалын эцэслэсэн хувилбар; ii) Үр дүнгийн үнэлгээний асуулга. Процессын үнэлгээний чиглүүлэх асуултууд; iii) Түршилтын судалгааны үр дүн; iv) Үр дүнгийн үнэлгээний нарийвчилсан ажлын төлөвлөгөө; v) Тоологчийн сургалтын төлөвлөгөө; vi) Сургалтын материал;	44 хоног	2024.05.31	ТХН, ХНХЯ
<b>Бүтээгдэхүүн 3. Явцын тайлан</b> i) Тоологчийн сургалт зохион байгуулсан тайлан; ii) Хөтөлбөрийн процессын болон үр дүнгийн үнэлгээний ажлын явцын тайлан; iii) Хөтөлбөрийн процессын болон үр дүнгийн үнэлгээний тайлангийн төсөл;	105 хоног	2024.08.31	ТХН, ХНХЯ

<p><b>Бүтээгдэхүүн 4. Эцсийн тайлан, зөвлөмж</b></p> <p>i) Үнэлгээний эцэслэсэн тайлан, сургамж, зөвлөмж; ii) Судалгааны ажлын тоон мэдээллийг архивлан (SPSS or STATA) төслийн нэгжид хүлээлгэн өгсөн дүгнэлт; iii) Үр дүнгийн үнэлгээний мөшгих судалгаанд анхаарах асуудлын талаарх санал зөвлөмж; iv) Сургамж, зөвлөмжийг багтаасан тайлангийн үр дүнг танилцуулах слайд (PPT)</p>	170 хоног	2024.11.30	ТХН, ХНХЯ
--	-----------	------------	-----------

**Гэрээний хугацаа:**

Гэрээний хугацаа нь 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс 2024 оын 11 дүгээр сарын 30-ны хооронд (8 сар) байна.

**Мониторинг, явцын хяналт, тайлагналтад тавигдах шаардлагууд:**

Зөвлөх байгууллага нь дээр дурдсан ажлыг ХНХЯ болон ОБУДХЭТ-ийн ТХН-ийн хяналт, Дэлхийн банкны зөвлөх, үндэсний зөвлөхийн удирдамж, хяналтын дор гүйцэтгэнэ. Зөвлөх байгууллагын ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- 1) Ажлын даалгаварт тусгасан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал;
- 2) Төлөвлөсөн ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлсэн байдал;
- 3) Гүйцэтгэсэн ажлын чанар.

Зөвлөх байгууллага нь ОБУДХЭТ-ийн ТХН-ийн багт ажлаа тайлагнана. ОБУДХЭТ-ийн баг нь ажлын даалгаврын дагуу хийгдэх ажлын техникийн болон удирдлагын хяналтыг хариуцна. Зөвлөх байгууллага нь гэрээний төлбөрийн хуваарьт заасан төлбөр авахын өмнө ХНХЯ болон ТХН-д Бүтээгдэхүүн хүлээж авах маягтыг бөглөж ирүүлнэ.

**Төлбөрийн хуваарь:**

Гэрээний үнийн дүн нь энд заасан хугацааг сунгасан эсэхийг үл харгалзан үр дүнд суурилсан тогтсон дүн байна. Зөвлөх байгууллага тохиролцсон бүтээгдэхүүнийг ХНХЯ/ТХН-д бүрэн хүлээлгэн өгсний дараа төлбөрийг доорх хуваарийн дагуу төлнө.

Үе шат	Төлбөрийн нийт үнийн дүнд эзлэх хувь
Бүтээгдэхүүн 1. Эхлэлийн тайлан	30%
Бүтээгдэхүүн 2. Үнэлгээний бэлтгэл ажлын тайлан	30%
Бүтээгдэхүүн 3. Явцын тайлан	30%
Бүтээгдэхүүн 4. Эцсийн тайлан, зөвлөмж	10%

Төлбөрийг нийлүүлсэн бүтээгдэхүүнийг ХНХЯ/ТХН хүлээн авч зөвшөөрсний дараа шилжүүлнэ.

**Нөхцөл шаардлагууд:**

Энэ даалгавартай холбогдуулан цуглуулсан мэдээлэл, гаргасан тайлан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) болон Дэлхийн банкны өмч болно. Сонгогдсон зөвлөх байгууллага нь энэ мэдээллийг өөрийн судалгаа эсвэл арилжааны зорилгоор ашиглаж болохгүй.

## ШААРДЛАГАТАЙ УР ЧАДВАР, АЖЛЫН ТУРШЛАГА

Зөвлөх байгууллага нь судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэдэг туршлага бүхий үндэсний ААНБ байна. Судалгааны байгууллага ба багийн гишүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

### i) Гэрээт байгууллагад тавигдах шаардлага

- Байгууллага нь 5-аас доошгүй жил ижил төстэй судалгаа, шинжилгээний ажлыг амжилттай гүйцэтгэсэн туршлагатай;
- Байгууллага нь санхүүгийн хувьд тус судалгааг гүйцэтгэх бүрэн чадамжтай бөгөөд өмнөх жилийн санхүүгийн орлого нь энэ судалгаанд санал болгож буй үнийн дүнгээс илүү байх;
- Судалгааны мэдээлэл цуглуулах тоологчдыг хурдан гэрээлэх, сургах чадамжтай байх;
- Олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно;

### ii) Судалгааны багийн гишүүдэд тавигдах шаардлага

*Багийн ахлагчид тавигдах шаардлага:*

- Эдийн засаг, хөдөлмөрийн эдийн засаг болон социологийн чиглэлээр магистр түүнээс дээш зэрэгтэй;
- Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, шинжилгээ болон/эсвэл нийгмийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай;
- Ижил төстэй 2-оос доошгүй хөтөлбөрийн үнэлгээ болон төслийн үнэлгээний судалгаа, шинжилгээ амжилттай гүйцэтгэсэн;

*Багийн гишүүдэд тавигдах шаардлага:*

- Эдийн засаг, социологи эсвэл холбогдох чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Түүвэрлэлт, асуулга боловсруулах, өгөгдөл цэвэрлэх/шинжилгээ зэрэг ижил төстэй үнэлгээг техникийн хувьд удирдаж байсан туршлагатай;
- Судалгаа, шинжилгээний ажилд 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай.

### iii) Үнийн санал

Гэрээний үнийн дүн нь зөвлөх байгууллагатай тохиролцсон тогтсон дүн байна. Гэрээний нийт үнийн дүн 170,000,000 (USD 48,500) хүртэл төгрөг байх бөгөөд ажлын даалгаварт заасан ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах бүх зардлууд багтсан байна.

Энэ ажлын даалгаварт заасан аль нэгэн бүтээгдэхүүнийг үндэслэлтэй нөхцөл байдлын улмаас гэрээ дуусгавар болохоос өмнө нийлүүлж амжаагүй бөгөөд үүнээс шалтгаалж гэрээний хугацааг сунгах тохиолдолд зөвлөх нэмэлт зардалгүйгээр бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

### Мониторинг, явцын хяналт, тайлагналтад тавигдах шаардлагууд:

#### iv) Санал ирүүлэх

- а) Үнэлгээний аргачлалын товч санал болон үнэлгээний арга хэрэгслийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө. Саналыг хавсралт 1-д хавсаргасан үзэл баримтлалын тэмдэглэлд үндэслэсэн байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт өөрчлөлт, сайжруулалтыг тусгана.
- б) Судалгааны байгууллагын ажлын туршлагыг багтаасан товч танилцуулга;
- в) Багийн гишүүдийн CV, боловсролын гэрчилгээний хуулбар;
- д) Байгууллагын сүүлийн хоёр жилийн санхүүгийн байдлын тайлан, аудитлагдсан тайлангийн хуулбарын хамт;
- е) Ижил төстэй ажлын туршлагыг нотлох 3-аас доошгүй лавлагаа тодорхойлолт;
- ф) Бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнийг тусгасан санхүүгийн санал, санхүүгийн саналыг төгрөгөөр илэрхийлэн ирүүлэх.

**v) Байгууллагыг сонгон шалгаруулах ерөнхий шалгуур**

Сонгон шалгаруулалтад техникийн санал (санал болгож буй аргачлал, туршлага, багийн гишүүдийн мэргэжил, үр чадвар) болон үнийн саналыг хослуулан үнэлнэ. Техникийн санал нь 80 хувь, үнийн санал нь үлдсэн 20 хувь байна.

Санхүүгийн үнэлгээг задлахдаа зөвхөн нийт техникийн онооны 70-аас доошгүй хувийг авсан тендерт оролцогчийн саналыг авч үзнэ.

Харин техникийн саналыг үнэлэхдээ дараах байдлаар үнэлнэ.

Техникийн шалгуур	Жин	Оноо
<b>Техникийн шалгуур 1: Байгууллагад тавигдах шаардлагууд</b>	<b>20</b>	<b>20</b>
Байгууллага нь ижил төстэй судалгаа, шинжилгээний чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай (1-5 оноо)		5
Байгууллага нь санхүүгийн хувьд тус судалгааг гүйцэтгэх бүрэн чадамжтай бөгөөд өмнөх жилийн санхүүгийн орлого нь энэ судалгаанд санал болгож буй үнийн дүнгээс илүү байх (1-5 оноо)		5
Байгууллагын сүүлийн хоёр жилийн санхүүгийн аудитлагдсан тайлангийн хуулбар (1-5 оноо)		5
Олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байсан туршлага (1-5 оноо)		5
<b>Техникийн шалгуур 2: Судалгааны багт тавигдах шаардлагууд</b>	<b>40</b>	<b>50</b>
Багийн ахлагч: <ul style="list-style-type: none"><li>Эдийн засаг, социологи эсвэл холбогдох чиглэлээр магистр түүнээс дээш зэрэг (1-10 оноо)</li><li>Судалгаа болон дүн шинжилгээний чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлага (1-10 оноо)</li><li>Ижил төстэй 2-оос доошгүй хөтөлбөрийн үнэлгээ болон төслийн үнэлгээний судалгаа, шинжилгээг амжилттай гүйцэтгэсэн (1-10 оноо)</li></ul>		30
Багийн гишүүд: <ul style="list-style-type: none"><li>Эдийн засаг, социологи эсвэл холбогдох чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэг (1-5 оноо)</li><li>Түүвэрлэлт, асуулга боловсруулах, өгөгдөл цэвэрлэх/шинжилгээ зэрэг ижил төстэй үнэлгээг техникийн хувьд удирдаж байсан туршлага (1-5 оноо)</li><li>Судалгаа, шинжилгээний ажилд 3-аас доошгүй жил ажилласан туршлага (1-10 оноо)</li></ul>		20
<b>Техникийн шалгуур 3: Аргачлалын товч санал, ажлын төлөвлөгөөнд тавигдах шаардлагууд</b>	<b>20</b>	<b>30</b>
Судалгааны ажлын даалгаварт өгөгдсөний дагуу хийгдэх судалгааны аргачлалын товч санал (1-20 оноо)		20
Ажлын төлөвлөгөөний найдвартай байдал, төлөвлөсөн хугацаанд судалгааг гүйцэтгэх санхүүгийн нөөц (1-10 оноо)		10
<b>Техникийн оноо</b>	<b>80</b>	<b>100</b>

## Хөтөлбөрийн үнэлгээний үзэл баримтлал

### 1.1. Хөтөлбөрийн товч мэдээлэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” (ОБҮДХЭТ)-ийг Дэлхийн банкны Олон Улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон техникийн дэмжлэгтэйгээр 2020-2024 онд хэрэгжүүлж байна. Төсөл нь ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүссэн хямралын үед зохих шалгуур хангасан ажил олгогч болон ажилтнуудад богино хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

Төсөл нь дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ: 1) Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тогтолцоог цогц байдлаар шинэчлэн ажил хайгч болон ажил олгогч нарт “үйлчлүүлэгч-төвтэй” үйлчилгээг хувийн зуучлалын байгууллагуудтай хамтран хүртээмжтэй хүргэх; 2) Төслийн хүрээнд сонгосон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэд нийцсэн байдлыг бэхжүүлэх; 3) Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулах; 4) Бизнес эрхлэгчид болон ажилтнуудад цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зохих шалгуур хангасан ажиллагчид болон ажил олгогчдод богино хугацааны тэтгэмж олгох бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 2-ын сонгосон хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэд нийцсэн байдлыг бэхжүүлэх ажлын хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн онцлог шинэлэг үр чадварыг хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлнэ. Тодруулбал, “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр” (энд Ур чадварын инновацийн хөтөлбөр буюу УЧИХ-ийг ойлгоно)-ийн онцлог нь эрэлтэд суурилсан зөвлөлдөх үүлзалт, салбарын холбоо/зөвлөлүүдийн оролцоо, бие даасан үнэлгээ, нийгэм-бүтээлч зан үйлийн үр чадвар олгох сургалтын нэмэлт модулиуд, мэргэшүүлэх сургалт, өмнөх мэдлэг, үр чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээ болон бусад шинэлэг зүйлсийг багтаасан.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс “Эрэлтэд нийцсэн үр чадвар олгох хөтөлбөр”-ийг 2023 оны 2 дугаар сард баталсан. ХНХЯ-ны харъяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт (ХНХСҮСИ) нь хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлыг хариуцаж ажиллана. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамжийг ХНХ-ын сайдын 2023 оны А/145 тоот тушаалаар баталсан бөгөөд удахгүй хэрэгжилтийг эхлүүлэхээр хүлээгдэж байна.

### 1.2. Үнэлгээний ажлын үндэслэл

Дээр дурдсан хөтөлбөрийн хүрээнд 700-аас доошгүй ажил хайгчдад эрэлтэд нийцсэн мэргэжлийн болон харилцаа, зан үйлийн үр чадвар олгох, 300 хүртэлх ажиллагчдыг мэргэшүүлэх сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. ХНХЯ нь төсөл дууссаны дараа ч тус хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн нэг болгон өргөжүүлэхээр төлөвлөсөн. Сургалт нь төлөвлөгөө ёсоор 2024 оны 03 дугаар сараас 2024 оны 11 дүгээр сарын хооронд зохион байгуулагдана.

---

Хүснэгт 1: Арга хэмжээ /Interventions/

---

**Арга хэмжээ**

**Хүрэх үр дүн**

---

1. Ур чадвар олгох сургалт	Хамгийн багадаа 700 хүн
2. Мэргэшүүлэх сургалт	Хамгийн багадаа 300 хүн

Иймд хөтөлбөрийн үнэлгээг хийхдээ хөтөлбөрийн процессын болон үр дүнгийн үнэлгээний хөтөлбөр, боловсруулан хэрэгжүүлэх аргачлалыг сургалтын модультай үялдуулан хийх шаардлагатай. Хөтөлбөрийн нөлөөллийн үнэлгээний судалгааг ХНХЯ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) хариуцаж ажиллана. Харин судалгааг гүйцэтгэх байгууллага нь Дэлхийн банкны болон үндэсний зөвлөхийн хамт судалгааны аргачлалыг боловсруулан, аргачлалын дагуу мэдээлэл цуглуулалт, дүн шинжилгээ хийж, үнэлгээний тайланг боловсруулах, зөвлөмж өгөх ажлыг хариуцаж ажиллана.

Хүснэгт 2. Хөтөлбөрийн хүрээ		
Үр дүн	Гарц	Орц
<ul style="list-style-type: none"> <li>✓ Зөөлөн үр чадварыг нэмэгдүүлэх /өөрийгөө ухамсарлах, өөрийгөө хөгжүүлэх, бие даан ажиллах, багаар ажиллах, бүтээлч, санаачлагатай, хариуцлагатай байх, асуудал шийдвэрлэх гэх мэт зан үйл, харилцааны үр чадварыг хөгжүүлэхэд анхаарах/</li> <li>✓ Хөдөлмөр эрхлэлт, ажлын цаг, гүйцэтгэл зэрэг хөдөлмөрийн зах зээлийн үр дүнг сайжруулах</li> </ul>	Ур чадвар эзэмшсэн ажил хайгчид	Ур чадвар олгох сургалт
<ul style="list-style-type: none"> <li>✓ Мэргэжлийн үр чадварыг нэмэгдүүлэх</li> </ul>	Мэргэжлийн үр чадвараа дээшлүүлсэн ажилтнууд	Мэргэшүүлэх сургалт

### 1.3. Үнэлгээний зорилго, анхаарах асуудал

Үнэлгээний үндсэн зорилго нь хөтөлбөрийн агуулга, сургалтын хэлбэр зорилгод нийцэж байгаа эсэх, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэх болон сургалтын үр шим хүртэгчдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцооны өөрчлөлтийг хэмжихэд оршино. Үнэлгээний зорилгоос хамааран хоёр төрлийн үнэлгээний ажлыг хийх шаардлагатай.

Хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжиж буй байдлыг хянах зорилгоор **процессын үнэлгээ** хийх бол үр шим хүртэгчдийн зан үйлийн хандлага болон хөдөлмөр эрхлэлтийн түвшний өөрчлөлтийг хянах **үр дүнгийн үнэлгээг** хийнэ. Үнэлгээний дүнд дараах асуултад хариулт эрэлхийлж, анхааран судална.

Хүснэгт 3. Үнэлгээний асуулт /Evaluation question/	
Процессын үнэлгээ	Үр дүнгийн үнэлгээ
Сургалт төлөвлөгөө ба журмын дагуу хэрэгжсэн үү?	Ажил хайгчдын зөөлөн үр чадварт өөрчлөлт орсон үү?
Суралцагчдыг сонгон шалгаруулалт тохиромжтой байсан үү?	Ажиллагчдын мэргэжлийн үр чадварт өөрчлөлт орсон үү?
Сургалтын хөтөлбөрийн агуулга, хэлбэр нь суралцагчдад ойлгомжтой байсан үү?	Хөдөлмөр эрхлэлтийн түвшинд өөрчлөлт гарсан үү?
Хөтөлбөр оролцогч талуудад ойлгомжтой байсан үү?	



## **1.4. Аргачлал**

Үнэлгээний аргачлал нь судалгааны зорилготой шууд хамааралтай. Иймд зорилгодоо хүрэхэд дараах хоёр төрлийн үнэлгээг хийнэ.

### **1.4.1. Процессын үнэлгээ**

Хөтөлбөр төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн эсэх болон тулгарсан хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор энэ үнэлгээг хийнэ. Процессын үнэлгээг хийхдээ хэрэгжих хугацааны үйл ажиллагааны хяналт (сургалтад оролцогчдын ирц, идэвхи, үнэлгээ, суралцагчдын хүйсийн байдал гэх мэт)-ыг хийхээс гадна хөтөлбөрт оролцогчдын санал бодлыг тандах зорилгоор чанарын судалгааг хийнэ. Ингэхдээ чанарын судалгааны арга болох бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулна. Хэрэгжилтийн хугацаанд хийх хяналтын үйл ажиллагааг шаардлагатай бол захиргааны мэдээлэл болон бусад мэдээллийг ашиглан хөтөлбөрийн хамт явуулна. Чанарын судалгааг хөтөлбөр хэрэгжсэний дараа зохион байгуулна.

### **Бүлгийн ярилцлага**

Сургалтын хөтөлбөр боловсруулагч, сургалтын байгууллагууд, салбарын яам, хэрэгжүүлэгч агентлаг, байгууллагын төлөөлүүд, төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөөллийг хамруулан хөтөлбөр хэрэгжих явцад тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлох, төлөвлөлт, агуулгын нийцтэй байдлыг хангах зорилгоор фокус бүлгийн ярилцлага зохион байгуулна. Хөтөлбөр хэрэгжүүлэгч олон байгууллагаас гадна аль болох олон оролцогчдын үзэл бодол, түршлагын талаар мэдэж авах зорилгоор ярилцлагыг хоёр удаа зохион байгуулна.

### **Ганцаарчилсан ярилцлага**

Бүлгийн ярилцлагын үеэр хөтөлбөрийн гол оролцогч талуудаас хөтөлбөр хэрэгжүүлэх явцад гарсан асуудлыг нарийвчлан тодруулах зорилгоор ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулна. Ганцаарчилсан ярилцлагад сонгогдох хүмүүс нь салбарын яам, хэрэгжүүлэгч агентлаг, мөн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан багш, сургалт зохион байгуулсан сургагч багш нарын төлөөлөл байна.

### **1.4.2. Үр дүнгийн үнэлгээ**

Хөтөлбөрийн үр шим хүртэгчдийн зан үйлийн хандлага болон хөдөлмөр эрхлэлтийн түвшний өөрчлөлтийг илрүүлэх зорилгоор энэ үнэлгээг хийнэ. Үнэлгээг хийхдээ Pre-Post (Before-and-after) буюу өмнө ба дараах байдлыг харьцуулах асуулгын аргыг санал болгож байна. Энэ аргачлалын онцлог нь тухайн хөтөлбөрт оролцогчдын сургалтын хөтөлбөрт хамрагдахаас нь өмнө хандлага, мэдлэг, үр чадварыг нь үнэлэх бөгөөд сургалтад хамрагдсаны дараа эдгээр үзүүлэлтүүдийг дахин үнэлж, өөрчлөлтийг тодруулна.

Энэ судалгаанд сургалтад оролцогчдын үр чадвар, хандлагыг тодорхойлох тусгай аргуудыг ашиглах боломжтой /нийгэм-бүтээл зан үйлийн үр чадварын үнэлгээ/.

Харин судалгаанд хамрагдах субъектын хувьд:

- ✓ Сургалтын хөтөлбөрт оролцогчид. Гэхдээ оролцогчдын хувьд асуулга нь ялгаатай байна. Ажил идэвхитэй хайгч 700 оролцогч болон мэргэшүүлэх сургалтад хамрагдах 300 оролцогчийн асуулгын агуулга ялгаатай байна.
- ✓ Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт ажилтнуудаа хамруулсан ААНБ-ын тухайн ажилтнуудыг удирдан ажилладаг ахлах мэргэжилтнүүд. Эдгээр мэргэжилтнүүдээс тухайн мэргэшүүлэх сургалтад оролцогчдын ажилдаа болон хамт олондоо хандах хандлага, мэргэжлийн үр чадварын өөрчлөлтийг тандан судлах юм.

Судалгааны давтамжийн хувьд дараах дарааллаар хийж болно:

✓ Суурь судалгаа /baseline survey/. Сургалт эхлэхээс өмнө суурь судалгааны мэдээлэл цуглуулна. Ингэснээр сургалтад оролцогчдын гарааны нөхцөл байдал, үр чадварын түвшинг үнэлнэ. Сургалт эхлэхээс өмнө оролцогчдын судалгааг зохион байгуулна. Тоологч нь оролцогчдоос асуулга авч, судалгааны агуулгын талаар асуусан бүх асуултад хариулна. Тухайн ангид 25-35 оролцогч байгаа гэж үзвэл нэг тоологч 3-5 хүнээс судалгаа авахаар төлөвлөж болно. Харин тухайн ажилтныг сургалтад явуулсан компанийн ахлах мэргэжилтний судалгааг сургалтын явцад авч болно.

✓ Сургалтын дараах судалгаа /follow-up survey/. Тус судалгааг сургалт дууссаны дараа шууд авч болно. Ингэснээр сургалтын агуулга, хэлбэр, үр дүнг үнэлэх боломжтой. Сургалт дууссаны дараа нэг тоологч 3 суралцагчаас судалгаа авна. Харин мэргэшүүлэх сургалтад ажилтнаа хамруулсан ААНБ-ын ахлах мэргэжилтнүүдийн судалгааг сургалтад хамрагдсанаас хойш, бэлтгэгдсэн ажилтныг ажлын байрандаа очсоноос 2-3 долоо хоногийн дараа авна.

✓ Мөшгих судалгаа /tracer survey/. Тус судалгааг сургалтаас 6 сарын дараа хийх болох бөгөөд сургалтад оролцогчдын зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тодруулахад нэмэлт захиргааны тоон мэдээг ашиглаж болно. Оролцогчдын регистрын дугаарт суурилсан бүртгэлийн тусламжтайгаар НДЕГ болон ХХҮЕГ-ын мэдээллийн санд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн түвшинг харьцуулан тодорхойлж болно.

Асуулгын маягтын тухайд судалгаанд CAPI (Computer Assisted Personal Interview) аргыг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх боломжтой.

### **1.4.3. Түүврийн дизайн**

#### **Процессын үнэлгээ**

Энэ үнэлгээний хүрээнд чанарын судалгаа хийгдэх бөгөөд дараах байдлаар ярилцлагад оролцогчдыг сонгоно.

#### **Бүлгийн ярилцлага**

Бүлгийн ярилцлага нь 2 удаа хийгдэх бөгөөд 10-12 оролцогчтой байна. Харин оролцогчдын хувьд:

1. Сургалтын хөтөлбөрийг боловсруулсан багш нар,
2. Сургалт зохион байгуулсан багш нар,
3. Салбарын яамны хөтөлбөр хэрэгжүүлсэн газар, хэлтэс,
4. Хөтөлбөр хэрэгжүүлэгч агентлаг,
5. Сургалтад хамрагдсан суралцагчид,
6. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөөлөл байна.

#### **Ганцаарчилсан ярилцлага**

Ганцаарчилсан ярилцлагыг бүлгийн ярилцлагаас цаашид нэмж тодруулах шаардлагатай асуудлыг тодруулах зорилгоор зохион байгуулна. Иймээс энэ ярилцлагад оролцогчид нь:

1. Сургалтын хөтөлбөр боловсруулсан багш нар,
2. Сургалт зохион байгуулсан багш нар,
3. Салбарын яамны хөтөлбөр хэрэгжүүлсэн газар, хэлтэс,
4. Сургалтын хөтөлбөрт хамрагдсан суралцагчид,
5. Хөтөлбөр хэрэгжүүлэгч агентлаг болон бусад оролцогч талууд байж болно.

Тооны тухайд асуудлын цар хүрээнээс хамааран дээр дурдсан оролцогчидтой ярилцлага хийхээр төлөвлөгдсөн болно.

### **Үр дүнгийн үнэлгээ**

Суурь судалгаанд сургалтанд хамрагдсан бүх оролцогчид хамрагдана. Сургалтын дараах судалгаагаар бүх оролцогчдоос судалгаа авах ба сургалтыг орхиж гарсан хүмүүсээс мөн судалгаа авна. Суралцагчид болон сургалтыг орхиж гарсан хүмүүс хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш зургаан сарын дараа мөшгих судалгаанд хамрагдана. Өөрөөр хэлбэл, мэргэжил олгох сургалтад хамрагдах 700 ажил хайгч, мэргэшүүлэх сургалтад хамрагдах 300 ажилтан эдгээр судалгаанд хамрагдана.

Харин мэргэшүүлэх сургалтад мэргэжилтнээ хамруулсан компаний ахлах мэргэжилтнүүдийн судалгааны тоо заавал 300 байх албагүй. Учир нь ААНБ-ын нэг газар, хэлтсээс 1-ээс дээш оролцогч хамруулах боломжтой юм.

## 1.5. Үнэлгээний ерөнхий хүрээ болон төлөвлөгөө

### 1.5.1. Ерөнхий хүрээ

Хүснэгт 4. Хөтөлбөрийн ерөнхий хүрээ					
Үнэлгээний төрөл	Орц	Гарц	Үр дүн	Нөлөөлөл	Хэмжих үзүүлэлт
Процессын үнэлгээ	Ур чадвар олгох сургалт	Ур чадвар эзэмшсэн ажил хайгчид	Хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн байх	Хөтөлбөр амжилттай хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн тогтмол хэрэгжүүлдэг хөтөлбөрийн нэг болсон байна.	✓ Хөтөлбөр төлөвлөгөө, журмын дагуу хэрэгжсэн эсэх
	Мэргэшүүлэх сургалт	Мэргэжлийн үр чадвараа дээшлүүлсэн ажилтнууд	Хөтөлбөр үр дүнтэй хэрэгжсэн байх		✓ Хөтөлбөрийн агуулга, хэлбэр тохиромжтой, тохируулсан эсэх ✓ Хөтөлбөр хэрэгжих үед гарсан хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэсэн арга зам
Үр дүнгийн үнэлгээ	Ур чадвар олгох сургалт	Ур чадвар эзэмшсэн ажил хайгчид	Мэргэжлийн болон зөөлөн үр чадвар дээшилсэн байх	Сургалтад хамрагдсан суралцагчдын мэргэжлийн болон зөөлөн үр чадвар нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинд өөрчлөлт орсон байна.	✓ Ажил хайгчдын зөөлөн үр чадвар нэмэгдсэн эсэх
	Мэргэшүүлэх сургалт	Мэргэжлийн үр чадвараа дээшлүүлсэн ажилтнууд	Мэргэжлийн болон зөөлөн үр чадвар дээшилсэн байх		✓ Ажилтнуудын мэргэжлийн үр чадвар нэмэгдсэн эсэх ✓ Хөтөлбөрт оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшин эсвэл ажлын гүйцэтгэл өөрчлөгдсөн эсэх

## 15.2.Ажлын төлөвлөгөө

Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах нэгж
Үнэлгээний аргачлалын үзэл баримтлал, үнэлгээ хийх үндэсний зөвлөх байгууллагын ажлын даалгавар	2024.01.20	Олон улсын болон үндэсний зөвлөх
Үнэлгээ хийх байгууллагыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	2024.04.01	ТХН
Үнэлгээний аргачлал, асуулгыг боловсруулах	Байгууллагыг сонгон шалгаруулснаас хойш 20 хоногийн дотор	Зөвлөх байгууллага, олон улсын болон үндэсний зөвлөх
Үнэлгээ хийх судлаачдын сургалт зохион байгуулах	Сургалтын өмнө	Зөвлөх байгууллага, олон улсын болон үндэсний зөвлөх
Үр дүнгийн үнэлгээний суурь судалгааг зохион байгуулах	Багц сургалт бүрийн өмнө	Зөвлөх байгууллага
Үр дүнгийн үнэлгээний сургалтын дараах судалгааг зохион байгуулах	Багц сургалт бүрийн дараа	Зөвлөх байгууллага
Мэдээлэл цуглуулалт болон дүн шинжилгээний чанарт хяналт тавих, үнэлгээний тайлангийн төслийг бэлтгэх	Үр дүнгийн үнэлгээ хийгдсэний дараа	Зөвлөх байгууллага, олон улсын болон үндэсний зөвлөх
Процессын үнэлгээний эхний бүлгийн ярилцлагыг зохион байгуулах	Сургалт дууссаны дараа долоо хоногт	Зөвлөх байгууллага
Процессын үнэлгээний хоёр дах бүлгийн ярилцлагыг зохион байгуулах	Сургалт дууссаны дараа долоо хоногт	Зөвлөх байгууллага
Процессын үнэлгээний ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулах	Бүлгийн ярилцлага дууссаны дараа	Зөвлөх байгууллага
Процессын үнэлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийх	Процессын үнэлгээ хийгдсэний дараа	Зөвлөх байгууллага, олон улсын болон үндэсний зөвлөх
Үр дүнгийн болон процессын үнэлгээний нэгдсэн тайланг бэлтгэх	Процессын болон үр дүнгийн үнэлгээ хийгдсэний дараа	Зөвлөх байгууллага, олон улсын болон үндэсний зөвлөх
Үр дүнгийн үнэлгээний мөшгих судалгааны аргачлалыг бэлтгэх	Эцсийн тайлан боловсруулах явцад	Зөвлөх байгууллага, олон улсын болон үндэсний зөвлөх

## **Хөтөлбөрийн үнэлгээний мэдээлэл цуглуулалт, мэдээллийн чанарын баталгаажуулалт ба дүн шинжилгээ хийх стратеги**

### **Судалгааны мэдээлэл цуглуулахад анхаарах асуудлууд**

Судалгааны тоон болон чанарын судалгаанд ашиглах аргуудаас хамааран судалгааны мэдээлэл цуглуулахад асуудал гарч болно.

Чанарын судалгааны хувьд бүлгийн ярилцлага, эсхүл ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулахдаа үнэлгээний зорилгоос хамааран чиглүүлэх асуултуудыг урьдчилан бэлтгэсэн байх хэрэгтэй.

Фокус бүлгийн хэлэлцүүлэг нь хөтөлбөрийн хэрэгжилтийн ололт амжилт, алдаа дутагдлыг сайтар судалж, тулгамдаж буй асуудалд холбогдох талууд анхаарлаа хандуулах боломж бүрдүүлнэ.

Түүнчлэн фокус бүлгийн ярилцлагын модератор чиглүүлэх асуултуудыг ялгамжтай байдлаар асуун, бүх оролцогчдын санал хүсэлтийг авч, дараагийн хэлэлцүүлэгт сайн бэлтгэсэн байх ёстой. Бүлгийн ярилцлагыг хөндлөнгийн судалгааны багийн ажиглагч нараар хянуулан, тодруулах асуултуудыг тавьж, асуудлын мөн чанарыг ойлгоход анхаарч ажиллана.

Ганцаарчилсан ярилцлагыг бүлгийн ярилцлагын дараа зохион байгуулна. Бүлгийн ярилцлагын үр дүнг боловсруулсны дараа зайлшгүй тодруулах, нэмж мэдээлэл авах зайлшгүй шаардлагатай асуудлыг ашиглан чиглүүлэх асуултуудыг бэлтгэнэ. Бүлгийн ярилцлагын үед хэрэв зарим оролцогчид өөрийн үзэл бодлоо дутуу илэрхийлсэн, эсхүл хөтөлбөрийн агуулгыг бэлтгэсэн багш нарын дэргэд ярихыг хүсээгүй бол ганцаарчилсан ярилцлагаар энэ бүгдийг тодруулах боломж бүрдэнэ.

Тоон судалгаа нь үр дүнг үнэлэхэд маш тохиромжтой арга бөгөөд зорилгоос хамааран асуулгын агуулга, бүтцийг тооцож гаргах хэрэгтэй. Тоон судалгааны асуулга боловсруулахад анхаарах зүйлсийг дараах дэд хэсэгт тайлбарласан болно.

Харин давтамжийн хувьд тоон судалгааг сургалтын өмнө болон дараа авч, үнэлэх нь тохиромжтой. Энэ үнэлгээнд сургалтын үр дүн болон үр чадварын өөрчлөлтийн нөлөөллийг харуулахад тохиромжтой аргуудыг ашиглаж болно.

Оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшний өөрчлөлт нь энэ хөтөлбөрийн чухал нөлөөллийн хүчин зүйл бөгөөд сургалтаас хойш тодорхой хугацааны дараа мөшгөх судалгаагаар тандан тодорхойлж болно. Гэхдээ энэ судалгааг санал асуулгаар зөвхөн оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тодруулахын тулд захиргааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж болно. Оролцогчийн регистрийн дугаарт суурилсан бүртгэлийн тусламжтайгаар Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн санд тулгуурлан хөдөлмөр эрхлэлтийн түвшинг судлах боломжтой.

Харин эдгээр сангуудад мэдээлэл нь байхгүй оролцогчдоос утсаар судалгаа авч, хөдөлмөр эрхлэлтийн түвшний өөрчлөлтийг тандаж болно.

### **Судалгааны асуулга боловсруулахад анхаарах асуудлууд**

Судалгааны асуулга нь дараах бүтэц, мэдээллийг агуулсан байна.

1. Хувь хүний ерөнхий мэдээлэл
  - Нас

- Хүйс
  - Боловсролын түвшин
  - Мэргэжил (ISCO code) болон мэргэшил/ур чадвар
  - Оршин суугаа байршил
  - Хөгжлийн бэрхшээл
2. Ажлын туршлага
- Өмнөх ажлын туршлага (ажлын төрөл, цалин болон бусад мэдээлэл)
  - Ажлаас гарсан шалтгаан
  - Ажил хийхэд тулгарч байсан хүндрэл, бэрхшээл
3. Ур чадварын үнэлгээ
- Зөөлөн ур чадвар
  - Мэргэжлийн ур чадвар
  - Нийгэм-бүтээлч зан үйлийн ур чадвар
4. Ирээдүйн төсөөлөл
- Ажлын байрны хүлээлт
  - Ур чадварын хүлээлт
  - Мэргэшил/ур чадварын өөрчлөлтийн хүлээлт
5. Бусад шаардагдах мэдээлэл

Судалгааны асуулгад зөөлөн ур чадварыг үнэлэх тусгай аргуудыг ашиглах бүрэн боломжтой.

#### **Аргачлалын дагуу судалгааг зохион байгуулах дараалал**

Судалгааны аргачлалын дагуу зохион байгуулахад дараах дарааллыг харгалзан, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгавал тохиромжтой.

- ✓ Судалгааны бэлтгэл ажил
- ✓ Баримт бичгийн шинжилгээ
- ✓ Судалгааны мэдээлэл цуглуулалт
- ✓ Мэдээлэл боловсруулалт, тайлан зөвлөмж тайлагналт

#### **Бэлтгэл ажлын хүрээнд**

- ✓ Судалгааны аргачлал болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;
- ✓ Аргачлалд нийцсэн судалгааны асуулгыг боловсруулах;
- ✓ CAPI (Computer Assisted Personal Interview) буюу таблет ашиглан судалгааны мэдээлэл цуглуулах аргаар судалгааг зохион байгуулах;
- ✓ Асуулга авах заавар, гарын авлагыг боловсруулах. Судалгааны мэдээлэл цуглуулах, түүнд хяналт тавих үйл ажиллагааг зөв, алдаа мадаггүй гүйцэтгэхэд гарын авлага маш чухал. Иймд мэдээлэл цуглуулах, боловсруулах, мэдээллийн санг архивлах, захиалагчдад хүлээлгэн өгөх судлаачид, багийн ахлагч, дата мэргэжилтнүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй гарын авлага гаргах;
- ✓ Судалгааг гүйцэтгэх багийн гишүүдэд сургалт зохион байгуулах;
- ✓ Чанарын судалгааны түүврийн хүрээг тогтоох судалгааны эх олонлогийг бэлтгэх;

#### **Баримт бичгийн шинжилгээ хийх ажлын хүрээнд**

- ✓ Аргачлалд тусгасны дагуу нийгэм ба эдийн засгийн дүн шинжилгээ хийхэд шаардагдах захиргааны тоон мэдээллийг цуглуулах;
- ✓ Төслийн болон УЧИХ-ийн баримт бичгийг ашиглах;

### **Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд**

- ✓ Асуулгыг боловсруулж дуусангуут сургалтад хамрагдах 2-3 сонгосон оролцогчоос туршилтын судалгаа авах;
- ✓ Судалгааны мэдээлэл цуглуулалтыг аргачлалын дагуу зохион байгуулах;
- ✓ Багийн ахлагч өдөр тутам цуглуулсан мэдээллийг хянаж, мэдээлэл цуглуулах явцын хяналтыг тавина;

### **Мэдээлэл боловсруулах, тайлан зөвлөмж бэлтгэх, хүлээлгэн өгөх ажлын хүрээнд**

- ✓ Мэдээллийн санд хяналт хийх, дүн шинжилгээ хийх талбарыг бэлтгэх;
- ✓ Судалгааны мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийхдээ судалгааны тусгай программуудыг ашиглана. Эдгээр судалгааны тусгай программ нь мэдээллийн сангийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд тохиромжтой;
- ✓ Судалгааны тайлан, зөвлөмжийг боловсруулах, ТХН-ийн багийн саналыг авах;
- ✓ Тайлан, зөвлөмжийг эцсийн байдлаар танилцуулах, хүлээлгэн өгөх.